

“УЛААНБААТАР ХОТ-100” АРХИВЫН БАРИМТ,БИЕТ ҮЗМЭРИЙН ҮЗЭСГЭЛЭНГИЙН ТАЙЛАН

2024 оны 10 дугаар сарын 30

Улаанбаатар хот

Монгол Улсын Нийслэл үүсэн байгуулагдсаны 385 жил, Нийслэл Хүрээг “Улаанбаатар хот” хэмээн нэрийдсэний 100 жилийн ойд зориулсан архивын баримт, биет үзмэр, гэрэл зургийн үзэсгэлэнг нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон нийслэлийн Архивын газар, Улаанбаатар хотын музей хамтран 2024 оны 10 дугаар сарын 23-29-ний өдрүүдэд Монголын Үндэсний музейн түр үзэсгэлэнгийн танхимд дэлгэн олон нийтэд танилцуулж ажиллаа.



Үзэсгэлэнгийн нээлтэд нийслэлийн Засаг даргын орлогч А.Амартүвшин, Монголын Үндэсний музейн захирал Доктор Г.Энхбат, нийслэлийн Архивын газрын дарга Н.Туул, Улаанбаатар хотын музейн захирал П.Даваасүрэн болон бусад зочид төлөөлөгч нар оролцлоо.



Үзэсгэлэн Монголын Үндэсний музейд 7 хоногийн хугацаанд дэлгэгдсэн бөгөөд нийт 400 гаруй иргэд хүүхэд багачуудад Нийслэл хотын нийгэм эдийн засаг, соёлын салбарт гарсан өөрчлөлт, Улсын Анхдугаар Их хурлаас нийслэл хотын талаар гаргасан тогтоол, шийдвэр, хотын захиргаа байгуулагдсан түүхэн үйл явцад холбогдох баримт, Нийслэл Хүрээ-Улаанбаатар хотын хөгжлийг харуулсан гэрэл зургийн тайлбар хийж ажиллаа.



Энэхүү түүхт ойг тохиолдуулан гаргаж буй үзэсгэлэнд Улсын Анхдугаар Их хуралд нийслэл хотоос сонгогдсон төлөөлөгчдийг батламжилсан баримт бичгүүд, Анхдугаар үндсэн хууль боловсруулах комиссын гишүүдийн гар бичмэл, хуулийн төсөл,



Нийслэл Хүрээг “Улаанбаатар” хэмээн нэрийдсэн тогтоол, хотын Засаг захиргаа, бүтэц, орон тоо, тамга, тэмдэг, нийслэлийн дэвсгэр нутаг, анхны хороодын зохион байгуулалт зэрэг 120 гаруй төрлийн чухал архивын баримт, эд өлөг, гэрэл зургуудыг олон нийтэд дэлгэн танилцуулж ажиллаа.